

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Үнэт цаасаар тооцогдсон үйл ажиллагааны орлогыг дутуу төвлөрүүлжээ.

“Стандарт
хэмжил
зүйн
хэлтсийн
2017 оны
үйл
ажиллагаа
ны үр дүн

2018 он

Гүйцэтгэсэн:

Ахлах аудитор

Б.Дагвасүрэн
Аудитор
Н.Батбилэг

Хянасан:

Тэргүүлэх аудитор
Л.Уламбаяр

Аудитын менежер
Г.Хашцэцэг

2018.05.29

Уг тайланг WWW.AUDIT.MN сайтаас үзнэ үү.

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл багийн байвал 99014227, 98825995 харилцана уу.

ХАЯГ: Завхан аймгийн
Аудитын газар
Улиастай сум, Жинст

309, 310 тоот өрөө

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
Аудит хийх үндэслэл, аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
Ерөнхий мэдээлэл	5
Үнэт цаасаар тооцогдсон үйл ажиллагааны орлогыг дутуу төвлөрүүлжээ.	6- 9
СХЗХ-ийн үйл ажиллагаа нь 2017 онд батлагдсан орон тоогоор ажиллаж, цалингийн сан төлөвлөсөн хэмжээнд зарцуулагджээ.....	9- 10
Зөвлөмж	11

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

- АДБОУС - Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
- ISO-
- СИ-
- СХЗХ - Стандарт хэмжилзүйн хэлтэс

1.Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Монгол улсын Ерөнхий аудитор 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, байгууллагын хөтөлбөр төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2.Аудитын зорилт

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2017 онд дэвшүүлсэн зорилго, зорилт, үйл ажиллагааны орлого бүрдүүлэлт, зарцуулалт, дамжин хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын ажил, орон тоо, цалин тогтоолт, боловсон хүчнийг хэрхэн сонгож томилж байгаа байдал, хөрөнгийн худалдан авалт, хадгалалт, хамгаалалт, төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн хөрөнгийг орлогод бүрэн авч, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа зэрэгт үнэлэлт дүгнэлт өгөх зорилготой. Төлөвлөлтийн үе шатанд үзсэн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл, тушаал шийдвэр, санхүүгийн баримтуудад үндэслэн дараахь зорилтуудыг дэвшүүлэн аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2017 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалт, хөрөнгө оруулалтын ажлын үр дүн
- Орон тоо, цалин тогтоолт, боловсон хүчнийг хэрхэн сонгож томилж байгаа байдал

3. Аудитын хамрах хүрээ:

Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2017 оны үйл ажиллагааг хамруулан шалгалаа.

4. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100), гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглах, холбогдох албан тушаалтан нартай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, санхүүгийн болон ажлын тайланг судлах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын хөтөлбөр болон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, үйл ажиллагаанд дүгнэлт өгч зорилго зөвлөмж боловсруулна. Мөрдөж буй хууль, дүрэм, журам, гэрээний биелэлтийг шалгаж, нөхцөл байдлыг судлан байгууллага, иргэдээс мэдээлэл авч түүвэрчлэн судалгаа хийхийн зэрэгцээ гарсан зөрчил дутагдлыг нотлох баримтаар баталгаажууллаа.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн шалгалтын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

5. Аудит хийхэд ашиглах шалгуур үзүүлэлтүүд:

- Төрийн Аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Хөдөлмөрийн тухай хууль
- Татварын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Холбогдох бусад хууль, журам эрхийн акт
- Стандартчилал, хэмжилзүйн үндэсний зөвлөлийн тогтоол, журам
- “Стандарт хэмжил зүйн хэлтсийн НББ-ийн бодлогын баримт бичиг” ном

6. Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Л.Уламбаяр, аудитын менежер Г.Хашцэцэг нар хянан удирдаж, Ахлах аудитор Б.Дагвасүрэн ахлан, аудитор Н.Батбилэг хамтран 2018 оны 05 дүгээр сарын 01-наас 2018 оны 5 дугаар сарын 31-ний хооронд 46 хүн өдөр ажиллан гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл:

Тус хэлтэс нь Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган, аймгийн хэмжээнд үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлж буй байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг стандартчилал, баталгаажуулалт, хэмжил зүйн бодлогоор дэмжин ажилласан байна.

2017 онд ерөнхий менежертэй байгуулсан менежерийн үр дүнгийн гэрээний хавсралт үйл ажиллагааны төлөвлөгөөнд 24 ажил үйлчилгээ нийлүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 96.5% биелэгджээ.

Чанарын менежментийн тогтолцооны тогтвортой байдалд магадлах төлөвлөгөөт аудитаар амжилттай сайн үнэлэгдэн, чанарын бүх баримт бичгүүдэд шүүлт хийж шинэчлэн сайжруулах, MNSISO 9001:2016 стандарт руу шилжих ажлын төлөвлөгөө боловсруулан амжилттай хэрэгжүүлж байна.

Албан хаагчдын дунд зохион байгуулах дотоод сургалтын төлөвлөгөөг оны эхэнд боловсруулан, хэлтсийн даргаар батлуулж, төлөвлөгөөний дотоодын сургалтуудыг хэлтсийн 10 албан хаагч 16 удаа зохион байгуулсан байна. Үүнд:

“Захиргааны ерөнхий хууль”, “Шилэн дансны хуулийн хэрэгжилт”, “Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2016 стандартын шилжилтийн арга зүй”, “Хөдөлгөөн эрүүл мэнд”, “Төрийн албан хаагчийн харилцааны ёс зүй”, “Сорьцын хяналтыг орон нутагт хэрэгжүүлэх арга замууд”, “Цахилгаан хэмжих хэрэгсэл”, “Танд тустай зөвлөгөө”, “Даралтын хэмжлийн нэр төрөл, даралтын тухай”, “Мэдээллийн технологи”, “Харилцааны ёс зүй”, “Эзэлхүүн зарцуулалтын хэмжлийн тухай”, “Олон улсын хэмжлийн нэгжийн СИ систем”, сэдэвт сургалтууд хийгдэж, сургалтанд албан хаагчид идэвхтэй оролцож, үнэлгээний хуудсаар сургалтын үйл явц, ач холбогдол, үр дүнг үнэлж, дараагийн сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон байна.

Бүлэг.1 Үнэт цаасаар тооцогдсон үйл ажиллагааны орлогыг дутуу төвлөрүүлжээ

Тус байгууллага нь улсын төсвөөс авах 139198.5 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн, үндсэн үйл ажиллагааны орлогоор 27511.2 мянган төгрөгийг төвлөрүүлэн, аймгийн Засаг даргын нөөц сангаас хөрөнгө оруулалтын зориулалтаар 10440.0 мянган төгрөгийн орлогыг нэмэлтээр авч нийт 177149.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн ажиллажээ.

Улсын төсвөөс авах 139198.5 мянган төгрөгийн санхүүжилт нь бодит зардалтай уялдсан нийт зардлын 102793,1 мянган төгрөг буюу 73.8% нь цалин НДШ-ийн зардал, 36405.4 мянган төгрөг нь бусад бараа үйлчилгээний зардал эзэлж байгаа бөгөөд төсвийн гүйцэтгэлээс дүгнэлт хийж үзэхэд санхүүжилт нь харьцангуй бодитой төлөвлөгдсөн гэж дүгнэх үндэстэй байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 14000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэлээр 27511.2 мянган төгрөг төвлөрүүлсэн нь төлөвлөгөөнөөс 13511.2 мянган төгрөгөөр буюу 96.5 %-иар давж биелэсэн байна.

Дээрх төвлөрүүлсэн орлогуудыг харилцах дансны орлогын хуулгуудтай тулган шалгахад дансанд бүрэн төвлөрчээ.

Монгол улсын Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 9 дүгээр зүйл, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9 дэх заалт, Шадар сайдын 2012 оны 44 дүгээр тушаалаар баталсан “Хэмжилзүйн зөвлөлийн дүрэм”- ийн 4.3 дахь заалт, “Хэмжих хэрэгсэлд улсын баталгаажуулалт хийх журам”- ын дагуу стандартын шаардлага хангасан Эзэлхүүн багтаамжийн хэмжүүр, хэмжих хэрэгсэлд баталгаажуулалт хийх, сумдад үйл ажиллагаа явуулж буй үйлвэрлэл, үйлчилгээний газруудад тохирлын үнэлгээ, магадлан хяналт хийж шаардлага хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээнд тохирлын гэрчилгээ олгох, сунгах ажлаар 2017 онд шинжээч, улсын шалгагч нар нь Улиастай сум, бусад сумдаар зүүн, урд, хойд, говийн гэсэн 4 чиглэлээр давхардсан тоогоор 20 ажилтан 42 хоног буюу 132 хүн өдөр ажиллаж 1411.0 мянган төгрөгийн албан томилолтын зардалтай ажилласан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг олгосон, бичилт хийсэн үнэт цаас, бичилт хийсэн нэхэмжлэл, бэлэн мөнгө хураах тасалбар, үлдэгдлийг баталгаажуулалтын шинжээч, улсын шалгагч, стандартын салбар сангийн мэргэжилтэнгүүдийн тайлантай нэг бүрчлэн тулган шалгалаа.

Өөрийн орлогыг бүрдүүлэхдээ Шадар сайд, Сангийн сайдын 2007 оны 11 дүгээр сарын 22-ны 314 тоот хамтарсан тушаал /Бүтээгдэхүүн, үйлчилгээний заавал баталгаажуулах ажлын төлбөр тооцох заавар/, Стандартчилал хэмжилзүйн газрын даргын 2015 оны 03 дугаар сарын 13-ны А/64 дугаар тушаал / Стандартын үнэ, ажил үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох тухай/, Монгол Улсын Шадар Сайдын 2015 оны 11 дугаар сарын 06-ны 117 дугаар тушаал/ хэмжил зүйн ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай/ тушаалуудыг баримтлан хураамжуудыг авч үндсэн үйл ажиллагааны орлогыг бүрдүүлсэн байна.

Олгогдсон гэрчилгээг нэр төрлөөр харуулбал :/ стандарт борлуулсан дүн ороогүй/

“Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2017 оны үйл ажиллагааны үр дүн

д/д	Ажилтнуудын нэр	Үйл ажиллагааны чиглэл	олгосон гэрчилгээ тоо-р	бичилт хийсэн гэрчилгээ тоо-р	үлдэгдэл гэрчилгээ /тоо-р/	алдаатай гэрчилгээ /тоо-р/	илүү /тоо-р/	дутуу /тоо-р/	нийт орлогын дүн аудитаар
1	Ц.Нинжбадгар	ШТС-ын түгээгүүр, хошуу, шилэн хэмжүүр	318	309	9				4700800
2	М.Наянбуу	бүх төрлийн жин, метр туухай	423	421	2				2553000
3	Б.Ганзориг	бүх төрлийн жин, метр туухай	1579	931	648				6186300
4	А.Билгүүн	даралтны аппарат, уурын зуухны макометр	50	34	16				170800
5	Д.Цэрэндулам	стандарт борлуулах хуудаснаас хамаарна	42/901х						602370
6	Б.Тунгалагтуяа	тохирлын гэрчилгээ баталгаажуулалтын төлбөр	526	526		2			13783480
7	М.Очбаяр	тохирлын гэрчилгээ баталгаажуулалтын төлбөр	23	16	7				425000
9	ДҮН		2919	2237	682	2	0	0	28421750

Тайлант онд 6 төрлөөр 2919 ш гэрчилгээг шалгагч нарт олгогдож 2237 ш гэрчилгээ бичигдэж 682 ш гэрчилгээ үлдэгдлээр тооцогдон 2 ш гэрчилгээ алдаатай бичигдэж нөхөн бичигдсэн байна.

Аудитаар дээрх хүснэгтэнд бичигдсэн 7 ажилтнуудад олгосон гэрчилгээг нэг бүрчлэн тулган шалгаж тооцоог гаргасан бөгөөд үйл ажиллагааны орлогыг дансанд төвлөрсөн эсэхийг бичигдсэн мөнгөн орлогын баримт, мөнгөн шилжүүлгийн баримт харилцахын хуулгатай тулган шалгав. Үүнд.

Стандарт хэмжил зүйн 2017 оны үндсэн үйл ажиллагааны орлогын тооцоо													
д/д	ажилтнуудын нэр	олгосон гэрчилгээ тоо-р	бичилт хийсэн гэрчилгээ	үлдэгдэл гэрчилгээ	алдаатай гэрчилгээ	нийт орлогын дүн аудитаар	СХЗХ-ийн тооцоо бодолтоор	нийт баримтаар дансанд орсон орлого	зөрүү шилжүүл гээр орох	албан томилолт онд олгосон	буцаан тооцсон	дутуу тооцсон	дутуу төвлөрүүлсэн орлого
1	Ц.Нинжбадгар	318	309	9		4700800	4700800	4700800	0				0
2	М.Наянбуу	423	421	2		2553000	2500000	2500000	53000				53000
3	Б.Ганзориг	1579	931	648		6186300	5979900	5979900	206400				206400
4	А.Билгүүн	50	34	16		170800	170800	170800	0				0
5	Д.Цэрэндулам	42/901х				602370	602370	602370	0				0
6	Б.Тунгалагтуяа	526	526		2	13783480	12372480	13132370	1411000	1411000	810000		601000
7	М.Очбаяр	23	16	7		425000	425000	425000	0				0
9	ДҮН	2919	2237	682	2	28421750	26751350	27511240	1670400	1411000	810000	601000	860400

Тус байгууллага нь нийт 28421.7 мянган төгрөгийн орлого оруулахаар үнэт цаас бичигдсэн байхад 27561.3 мянган төгрөгийн орлого орохоор тооцоо бодсон нь 860.4 мянган төгрөгөөр орлогыг дутуу тооцож харилцах дансанд 27511.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлэн СХЗГ азарт төвлөрүүлсэн байна.

Орлого бүрдүүлэлттэй холбоотой дараахь зөрчлүүд илэрч байна. Үүнд:

- Шалгагч нар сумдад албан томилолтоор ажиллаж үйлчилгээний хураамжийн орлогын 5780.2 мянган төгрөгийг бэлнээр хураан авсан бөгөөд мөнгөн орлогыг 5-30 хоногийн дотор шалгагч дээр байлгаж дансанд тушаадаг, 2016 оны мөнгөн орлогын 1 ш квитанцын орлого 2017 онд тушаагдсан
- Мөн шалгагч нарын үнэт цаас, орлогын тооцоог жилийн эцэст хийхдээ

нэхэмжлэлээр орох орлогын үлдэгдлийг тооцож баталгаажуулаагүй, авлага үүсгэлгүй орхигдуулсан зөрчлөөс 259.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоогдлоо

- Хөдөө сумдад томилолтоор ажиллаж байгаа шинжээч, шалгагч нарын албан томилолтын мөнгийг олгож явуулдаггүй, үйл ажиллагааны хураамжийн орлогоос 1411.0 мянган төгрөгийн томилолтын тооцоог хийсэн зөрчлөөс үйл ажиллагааны орлогыг дутуу тооцсон 601.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоогдлоо

Дээрх зөрчлүүд нь “Үнэт цаас, тооцоот баримтуудыг хэрэглэх, хадгалах, бүртгэх, тэдгээрийн зарцуулалтанд хяналт тавих журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.5-д/ бэлэн мөнгө хураах, тасалбараар ажил үйлчилгээний төлбөрийг авч болох төлбөрийн нийт дүн 200.0/ хоёр зуун мянган/ төгрөгөөс хэтрэхгүй байна. Бэлэн мөнгөөр хурааж авсан орлогыг холбогдох албан тушаалтан 5 хоногийн дотор данс болон кассанд тушаана/-гэсэн заалтыг зөрчсөн байна.

Орлогыг бэлнээр хураах нь мөнгө дутаах, алдагдах, шалгагч нарын гар дээр мөнгө эргэлдэх эрсдэлүүдийг үүсгэх магадлалтай тул орлогыг нэхэмжлэлээр тооцож журамд заасан хугацаанд дансанд тушаах шаардлагатай гэж үзлээ.

СХЗГ-аас үндсэн үйл ажиллагааны орлогыг баталж өгдөг нь бодит орлоготой уялдаггүй баталж өгсөн хэмжээнд үндсэн үйл ажиллагааны орлогыг ямар нэгэн хүндрэлгүй биелүүлдэг бөгөөд тоолуур баталгаажуулалт болон бусад төлбөрийн орлого нэмэгдэх боломж байна.

Тус байгууллага нь үндсэн үйл ажиллагааны орлогыг бодит байдлаас доогуур төлөвлөж өгсөн нь орлогын төлөвлөгөө биелүүлэхэд тавигдах шаардлага сулрах, орлогыг төвлөрүүлэхэд хяналт алдагдах эрсдэл ажиглагдаж байгаа тул орлогыг тухайн жилийн ажлын төлөвлөгөөтэй уялдуулан бодитой төлөвлөх шаардлагатай байна гэж үзлээ.

Үнэт цаасаар тооцогдсон үйл ажиллагааны орлогыг 860.4 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлснийг төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

Тус байгууллага нь төвлөрүүлсэн 177149.7 мянган төгрөгийн орлогоос үндсэн үйл ажиллагааны 27511.2 мянган төгрөгийн орлого, 2017 оны 12 дугаар сарын 31-ний харилцахын үлдэгдэл 13.5 мянган төгрөг нийт 27524.8 мянган төгрөгийг Стандарт хэмжил зүйн газарт төвлөрүүлж 149624.9 мянган төгрөгийн төсвийн зарлагатай ажилласан байна.

Төсвийн зарцуулалтыг хянаж үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд ажилласан бөгөөд зардлын нэр төрлөөр авч үзвэл хог хаягдлын зардал 78.1 мянган төгрөгөөр, гэрэл цахилгаан 90.0 мянган төгрөгөөр хэмнэгдэж, цэвэр бохир усны зардлыг 90.8 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 51.8 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулжээ.

Төсвийн зарцуулалттай холбоотой алдаа зөрчил илрээгүй, батлагдсан төсвийг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

Хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжүүдийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж байна.

Хэлтсийн үйл ажиллагааг хэвийн, хөнгөн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангахын тулд эталон цахилгаан жин, эмнэлгийн цусны даралтын аппарат, хүнсний мерик, хийн шатахуун түгээгүүр шалгах эталон төхөөрөмжийг нийлүүлэхийг 2017 оны үр дүнгийн гэрээнд тусган бүрэн хэрэгжүүлсэн байна.

Дээрх хөрөнгүүдийн 10440.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэж өгсөн бөгөөд 10л-ийн хүнсний мерик 580.0 мянган төгрөгөөр “Электрон түлхүүр” ХХК-аас, эмнэлгийн цусны даралтын аппарат 1ш- 5120.0 мянган төгрөгөөр “Хими” ХХК-аас, эталон цахилгаан жин 1ш 1440.0 мянган төгрөгөөр, хийн шатахуун түгээгүүр шалгах эталон төхөөрөмж 1ш 3300.0 мянган төгрөгөөр “Хэмжих хэрэгсэл” ХХК-аас байгууллагын даргатай байгуулсан гэрээний дагуу бүрэн нийлүүлэгдсэн байна.

Тоног төхөөрөмжүүдийн ашиглалтыг байгууллага дээр очиж үзэхэд зориулалтын дагуу бүрэн ашиглаж байгаа бөгөөд бүртгэлд бүрэн тусгасан, өөр хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүй байна.



Тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнээр ажлын чанар сайжирч тайлант оны үндсэн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 13000.0 мянган төгрөгөөр нэмэгдэж үр дүн үр өгөөж нэмэгдсэн байна.

Бүлэг 2. СХЗХ-ийн үйл ажиллагаа нь 2017 онд батлагдсан орон тоогоор ажиллаж, цалингийн сан төлөвлөсөн хэмжээнд зарцуулагджээ.

Тус байгууллагын 2017 оны орон тоо, цалингийн санг СХЗХ-ийн даргын 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/01 тоот тушаалаар 12 орон тоо ажиллаж, цалинг сарын 7717.2 мянган төгрөгөөр жилийн 92606.4 мянган төгрөг зарцуулахаар баталсан байна.

Мөн санг СХЗХ-ийн даргын 2017 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн А/05 тоот тушаалаар / Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар заалт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтуудыг/ үндэслэн 04 дүгээр сарын нэгнээс эхлэн ажилтан албан хаагчдад унаа, хоолны хөнгөлөлтийг 65.0 мянган төгрөгөөр бодож олгохоор сарын 780.0 мянган төгрөг

жилийн 7020.0 мянган төгрөгөөр цалингийн санг нэмэгдүүлэн баталсан байна.


Ажилтнуудын цалинг олгохдоо Засгийн газрын 2007 оны 354 дүгээр тогтоол, 2013 оны 332-р тогтоол, Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоол, 2002 оны 195 дугаар тогтоолуудыг баримтлан олгосон байна.

Нийт 99760.8 мянган төгрөгийн цалингийн зардал гаргахаар төлөвлөгдсөнөөс 99753.7 мянган төгрөгийн цалингийн зардал гаргасан нь батлагдсан төсөвт зарцуулагдсан байна.

Тайлант жилд ажилтнуудтай холбоотой 19 тушаал гарсан бөгөөд тушаал шийдвэрүүд нь холбогдох хуулийн дагуу хийгджээ.

Тайлант жилд батлагдсан орон тоонд ажилласан бөгөөд цалинтай холбоотой авлага, өглөг үүсээгүй байна.

Тус байгууллагын ажилтнууд нь улсад 3.7-33.2 жил, төрд 1-29.6 жил ажилласан ажлын туршлагатай боловсон хүчний баг ажиллаж байна. Шалгагч нарын сургалтанд хамрагдсан байдал, эрхийн гэрчилгээг нэг бүрчлэн тулган шалгахад зөрчил илрээгүй, шалгагч нарт хэрэглэгдэх үнэмлэх, багаж хэрэгслийг тулган үзлээ.



Тус байгууллагын 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт дотоод аудитын алба төлөвлөгөөт шалгалт хийж цалинтай холбоотой 195.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож барагдуулсан байна.

Аудитаар орон тоо, цалин тогтоолт, зарцуулалттай холбоотой зөрчил, дутагдал илэрээгүй болно.

Гүйцэтгэлийн аудитаар 6604.2 мянган төгрөгийн зөрчил илэрч 860.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоогдон 13860.4 мянган төгрөгийн үр өгөөжийг тооцон 4 заалт бүхий зөвлөмж өгөгдлөө .

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ

АУДИТОР

Л.УЛАМБАЯР



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн дараахь зөвлөмжийг өгч байна.

1. Үндсэн үйл ажиллагааны орлогыг тухайн жилийн ажлын төлөвлөгөөтэй уялдуулан бодитой төлөвлөх,
2. Шалгагч нарын үйлчилгээний хураамжийн орлогыг “Үнэт цаас, тооцоот баримтуудыг хэрэглэх, хадгалах, бүртгэх, тэдгээрийн зарцуулалтанд хяналт тавих журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.5-д/ бэлэн мөнгө хураах тасалбараар ажил үйлчилгээний төлбөрийг авч болох төлбөрийн нийт дүн 200.0/ хоёр зуун мянган/ төгрөгөөс хэтрэхгүй байна. Бэлэн мөнгөөр хурааж авсан орлогыг холбогдох албан тушаалтан 5 хоногийн дотор данс болон кассанд тушаана/- гэсэн заалтыг баримтлан тушааж хэвших,
3. Шалгагч нарын үнэт цаас, орлогын тооцоог жилийн эцэст хийхдээ бичигдсэн үнэт цаас орсон орлогыг бэлнээр болон нэхэмжлэлээр орсон орлоготой нэг бүрчлэн тулган баталгаажуулж тайлант онд бүрэн төвлөрүүлэх,
4. Хөдөө сумдад томилолтоор ажиллаж байгаа шинжээч, шалгагч нарын албан томилолтын мөнгийг үйл ажиллагааны хураамжийн орлогоос олгодог байдлыг таслан зогсоох
5. Гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн 4 заалт бүхий зөвлөмж, 6604.2 мянган төгрөгийн зөрчил, 860.4 мянган төгрөгийн төлбөрийн актыг тогтоосон хугацаанд барагдуулж 2018 оны 6 дугаар сарын 20-ны дотор албан тоотоор хариу ирүүлэх

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Л.УЛАМБАЯР

Стандарт хэмжидзүйн хэлтэс дээр очиж ажилласан тэмдэглэл

Тус хэлтсийн гүйцэтгэлийн аудитын ажлыг 5 дугаар сарын 01-ээс эхэлж санхүүгийн зарцуулалтын баримт, үндсэн үйл ажиллагааны орлого бүрдүүлэлттэй холбоотой үнэт цаас, орлогын дансны хуулгын тулгалтуудыг хийж дуусган, 25 наас шалгагч нарыг дуудан үнэт цаасны тооцоо, орлого тушаасан баримтуудыг тулган баталгаажуулав.

Тулган баталгаажуулалтаар 3 шалгагчийн төвлөрүүлэх орлого 860,4 мянган төгрөгөөр дутуу төвлөрсөн болох нь илэрсэн

Аудитын явцад тус байгууллагын шалгагч нар 2018 оны төлөвлөгөөт ажлаар сумдад ажилласан бөгөөд 2018.05.28-нд тус байгуулага дээр очиж ажилласан Үүнд: Тоног төхөөрөмжүүдийн ашиглалтыг байгууллага дээр очиж үзэхэд зориулалтын дагуу бүрэн ашиглаж байгаа бөгөөд бүртгэлд бүрэн тусгасан байна

Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэж өгсөн 10440.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүхий 10л-ийн хүнсний мерик 580.0 мянган төгрөгөөр “Электрон түлхүүр” ХХК-аас, эмнэлгийн цусны даралтын аппарат 1ш- 5120.0 мянган төгрөгөөр “Хими” ХХК-аас, эталон цахилгаан жин 1ш 1440.0 мянган төгрөгөөр, хийн шатахуун түгээгүүр шалгах эталон төхөөрмөж 1ш 3300.0 мянган төгрөгөөр “ Хэмжих хэрэгсэл” гэрээний дагуу бүрэн нийлүүлэгдснийг зургийг авч тайланд оруулав

Мөн шалгагч нарын мэргэжлийн гэрчилгээ сунгалт, сургалтанд хамрагдсан байдал, ажилд хэрэглэж буй мэргэжлийн үнэмлэх, лац, тэмдэгийн хүчин төгөлдөр байдлыг үзэж хянав.

Тус байгууллагын дарга нь Отгонтэнгэр хайрханы тахилгын ажилд оролцохоор явсан байсан тул тайлагналын явцын талаар танилцуулах боломжгүй байсан.

Тайлан, зөрчил төлбөрийн жагсаалтыг файлаар, цаасаар хүргүүлж танилцуулан хариуг тоотоор авсан

Тайлангийн төсөл, зөрчил төлбөрийг 5 сарын 31-нд удирдлагын зөвлөлийн хуралб оруулав.

Ахлах аудитор

Б.Дагвасүрэн

Хурлын тэмдэглэл

СХЗХ-ийн гүйцэтгэлийн аудитын дүнгийн хурал 10.00 цагт эхлэв

СХЗХ-ийн гүйцэтгэлийн аудитын дүнгийн хуралд Дарга тэргүүлэх аудитор Л.Уламбаяр, аудитын менежер Г.Хашцэцэг Ахлах аудитор Б.Дагвасүрэн, Д.Оюунжаргал, Ч.Бямбасүрэн, СХЗХ-ээс дарга Г.Цэцэгээ, нягтлан бодогч В.Золжаргал, нярав Намжилмаа нар оролцов.

Гүйцэтгэлийн аудитын тайлан зөрчил төлбөрийн талаар Ахлах аудитор Б.Дагвасүрэн танилцуулав.

Аудитаар 6604.2 мянган төгрөгийн зөрчил, 860.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоогдсон.

Дарга тэргүүлэх аудитор Л.Уламбаяр: Үнэт цаасны болон үндсэн үйл ажиллагааны орлогоос яагаад албан томилолтын мөнгө олгож байна, томилолтын зардлыг яаж төлөвлөж байна.

Дарга Г.Цэцэгээ: Тухай үед нь төсвийн албан томилолтын зардал байдгүй, хүрэлцэдгүй болохоор, 2018 оноос үндсэн үйл ажиллагааны орлогоос томилолтын зардал олгодог байдлыг таслан зогсоосон

Аудитын менежер Г.Хашцэцэг: төлбөрийн акт тогтоогдож байгаа 601,0 мянган төгрөгийг хаанаас яаж төлөх гэж байна.Тооцоог хангалтгүй хийсэн албан томилолтын тооцоог шахаж тооцоо бодоогүй нягтлан бодогчийн хариуцлагагүй байдал гарч байгаа тул нягтлан бодогч л хариуцах болж байна

Нягтлан бодогч В.Золжаргал: албан томилолтын зардлыг шилжүүлсэн харин буцааж тооцоогүй алдаа гарлаа. Би ойлгож байна

Ахлах аудитор Б.Дагвасүрэн: Гүйцэтгэлийн аудитын тайлан хугацаандаа дуусч үе шатны хяналтаар, удирдлагын зөвлөлийн хурлаар орсон. Нягтлан бодогч Золжаргал Солонгос улсад эмчилгээнд явсан тул 601.0 мянган төгрөгийн актыг тодорлуулахаар хүлээсэн боловч нягтлан бодогчийн тайлбарласан зүйл нотлогдох баримтаар дэмжигдээгүй тул 601.0 мянган төгрөгийн актыг хэвээр байлгаар шийдвэрлэв.

Цаашид үндсэн үйл ажиллагааны орлогоос албан томилолтын зардал олгохгүй байх, жилийн эцэст үнэт цаасны тооцоог шалгагч бүрээр хийж үнэт цаасны үлдэгдэл, бичсэн орлогыг харицахын хуулгатай тулган баталгаажуулж тайлант онд орлогыг бүрэн барагдуулж байх шаардлагатай байна.

Мөн шалгагч нар бэлэн мөнгийг бэлнээр хуураасан тохиолдолд журамд заасан хугацаанд дансанд тушааж байх, орон тоо цалин тогтоолтын хувьд хууль журмын дагуу байгаа бөгөөд зөрчил төлбөр илэрээгүй

Ахлах аудитор Д.Оюунжаргал, Ч.Бямбасүрэн: тайланд санал алга төлбөрийн акт, тайланг зөвшөөрч байна.

Г.Цэцэгээ: өөр санал алга тайлан, зөвлөмж, төлбөрийн актыг хүлээн зөвшөөрч байна.

Дарга тэргүүлэх аудитор Л.Уламбаяр: албан томилолтын зардлыг хөдөө орон нутагт ажиллах сарын өмнөх сард баталж өгөх нь зөв гэж үзэж байна өөр санал алга

Тайлан, зөрчил төлбөрийн жагсаалт актын төлбөрийн хяналтын хуудас, актын хуудсыг эцэслэн хэвлэж албан тоотоор байгууллагад хүргүүлэх хурлыг дуусгав

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

Ахлах аудитор

Б.Дагвасүрэн